2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10885.4
210201	Тэтгэврийн даатгал	10885.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	113.5
210301	Гэрэл, цахилгаан	113.5
2104	Хангамж, бараа материалын зардал	41728.5
210401	Бичиг хэрэг	2126.2
210402	Тээвэр, шатахуун	10287.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1204.5
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	25109.9
2105	Нормативт зардал	135005.3
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	128713.8
210502	Хоол, хүнс	3491.5
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2800.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	72029.2
210601	Багаж, техник, хэрэгсэл	67029.2

210602	Тавилга	5000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7250.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7250.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	171838.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	171275.2
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	563.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	49059.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	44005.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	44005.0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	5054.8
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	5054.8
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	575479.1
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	575479.1
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1000.0
131103	ЗГНХ,ЗДНХерөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	153664.9
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	41420.6
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	379393.5
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	976.0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	976.0

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Баяндэлгэр сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Л.Аваадорж танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2022 оны 03 дугаар сарын 5-аас 2022 оны 03 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Оюунболд гүйцэтгэв.

Баяндэлгэр сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 05-ний өдрийн 5 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Баяндэлгэр сумын ТТЗ-ын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл

зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Хурал, Засаг дарга, доод шатны нутгийн захиргааны байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах;
- Хууль тогтоомж, Засгийн газар, Хурал, Засаг даргын шийдвэрийг биелүүлэх үүрэг бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах, гүйцэтгэлд нь хяналт тавьж үр дүнг тооцох;
- Төрийн захиргааны ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах;
- Тухайн шатны Хурлын хэвийн үйл ажиллагааг хангаж аж ахуйн талаар үйлчлэх.
- Татварын алба хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан шаардсан мэдээллийг гаргаж өгөх;

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Баяндэлгэр сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлын 4489.4 сая төгрөгийн 2 хувь буюу 89.0 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

~~Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна. Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 139172.7 мянга, эцсийн үлдэгдэл 668932.0 мянга төгрөг болж, 529759.3 мянган төгрөгөөр өссөн байна.~~

Хүснэгт №1 ~~Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/~~

<u>Үзүүлэлт</u>	<u>Эхний үлдэгдэл</u>	<u>Эцсийн үлдэгдэл</u>	<u>Өсөлт (+), Бууралт (-)</u>	<u>Дүнд эзлэх хувь</u>
Төрийн сан дахь харилцах	139103.6	664412.4	525308.8	79.0
Арилжааны банкин дахь харилцах	69.1	4519.6	4450.5	98.4

Дүн	139172.7	668932.0	529759.3
------------	-----------------	-----------------	-----------------

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 664412.4 мянган төгрөг төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд, 4519.6 мянган төгрөг арилжааны банкны дансанд байршиж байна. Үүнд:

- Орон нутгийн ерөнхий орлогын үлдэгдэл 595083.6 мянга
- Орон нутгийн хөгжлийн сангийн үлдэгдэл 13090.6 мянга
- Сум хөгжүүлэх сангийн үлдэгдэл 55245.6 мянга
- Эрүүл мэндийн төвийн үлдэгдэл 992.5 мянга
- Эмийн эргэлтийн сан /Бум игүшн фарм ХХК/-гийн үлдэгдэл 4519.6 мянган төгрөг байна.

3.5.2 Авлага

Авлага ~~Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.~~ дансны эхний үлдэгдэл 239629.9 мянга, эцсийн үлдэгдэл 384132.6 мянган төгрөг болж, 144502.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	5797.8	173836.9	168039.1
Бусад авлага	233832.1	210295.7	-23536.4
Дүн	239629.9	384132.6	144502.7

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай буюу сүүлийн 1-9 жилийн хугацаанд үүссэн сум хөгжүүлэх сангаас иргэдэд олгосон 210295.7 мянган төгрөгийн авлага байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8 /төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх/ дахь заалттай нийцэхгүй. Мөн зээл хүссэн бусад иргэдэд зээлийн эх үүсвэр дутагдах зэрэг үр дагавартай байна.

~~3.5.4 Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна. Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.~~ **Бараа материал**

Бараа материалын ~~Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.~~ эхний үлдэгдэл 240623.3 мянга, эцсийн үлдэгдэл 286734.3 мянган төгрөг болж, 46111.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Эм боох материал	18926.2	33792.3	14866.1
Бичиг хэргийн материал	2713.2	4366.2	1653.0
Аж ахуйн материал	181674.6	204941.0	23266.4
Түлш, шатах тослох материал	1434.0	2598.7	1164.7
Хүнсний материал	8808.6	1256.8	-7551.8
Бусад хангамжийн материал	23441.7	35944.1	12502.4
Мал амьтад	3625.0	3835.0	210.0
Дүн	240623.3	286734.3	46110.8

Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдах боломжтой боловч их хэмжээний үлдэгдэлтэй 204941.0 мянган төгрөгийн аж ахуйн материал байгаа нь үрэгдэж цаашид ашиглагдах боломжгүй болох үр дагавартай байна.

Аудитын илрүүлэлт: Ерөнхий боловсролын сургууль үйл ажиллагаанд ашигласан 4700.0 мянган төгрөгийн материалыг зарлага болгохгүйгээр үлдээдлээр тайлагнасан, аж ахуйн материал дансанд 11200.0 мянган төгрөгийн сагсны самбар, гар бөмбөгийн тор зэргийг илүү бүртгэсэн байна.

3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна. эхний үлдэгдэл 6242029.9 мянга, эцсийн үлдэгдэл 6837046.1 мянган төгрөг болж, 595016.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж, орон сууц	3743102.7	3758102.7	15000.0
Тээврийн хэрэгсэл	231135.8	439735.8	208600.0
Машин, тоног төхөөрөмж	674179.4	859132.3	184952.9
Тавилга, эд хогшил	337809.2	371113.2	33304.0
Номын фонд	49959.2	55976.4	6017.2
Бусад үндсэн хөрөнгө	1109278.2	1256420.4	147142.2
Программ хангамж	3852.1	3852.1	0
Бусад биет бус хөрөнгө	92713.0	92713.0	0
Дүн	6242029.9	6837046.1	595016.2

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 87672.6 мянга, балансаас балансад шилжүүлэн авсан 32400.0 мянга, үнэ төлбөргүй хандиваар авсан 169601.4 мянган төгрөгөөр нэмэгдэж, хасагдсан хөрөнгө байхгүй.

Аудитын илрүүлэлт: Ерөнхий боловсролын сургууль үндсэн хөрөнгийн дансанд 4900.0 мянган төгрөгийн аж ахуйн зориулалттай материал бүртгэсэн. Цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургууль, Эрүүл мэндийн төв, Засаг даргын тамгын газруудад үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 326 нэр төрлийн хөрөнгө бүртгэлтэй байгаа зөрчил нь УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлд тусгасан "Хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг наад зах нь санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үзэх ба хэрэв хүлээлт нь өмнөх тооцооллоос өөр байвал уг өөрчлөлтийг УСНББОУС 3 тооцооллын өөрчлөлтийн дагуу тайлагнана" заалттай нийцэхгүй байна.

3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна. эхний үлдэгдэл 22966.0 мянга, эцсийн үлдэгдэл 32849.9 мянган төгрөг болж, 9883.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/

<u>Үзүүлэлт</u>	<u>Эхний үлдэгдэл</u>	<u>Эцсийн үлдэгдэл</u>	<u>Өссөн+ Буурсан -</u>	<u>Дүнд эзлэх хувь</u>
-----------------	-----------------------	------------------------	-----------------------------	------------------------

<u>Богино хугацаат өр төлбөр дүн</u>	22966.0	32849.9	9883.9	30.1
--------------------------------------	---------	---------	--------	------

Нийт дүн

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 8990.0 мянган төгрөгийн ажилчидтай холбогдсон, 19557.8 мянган төгрөгийн байгууллагад төлөх, 4300.0 мянган төгрөгийн дансны өр байна. Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэлгүй байна.

Аудитын илрүүлэлт: Ерөнхий боловсролын сургуулийн жилийн эцэст харилцах дансны хуулгыг хянаагүйгээс харилцагч байгууллагад шилжүүлсэн гүйлгээ буцаж үдийн цайны зардлаас 6800.0 мянга, халаалтын зардлаас 6100.0 мянга, цалингийн зардлаас 9000.0 мянга нийт 21900.0 мянган төгрөгийн өглөг үүссэн байна.

3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 1388500.0 мянга, эцсийн үлдэгдэл 1388500.0 мянган төгрөг байна.

Хүснэгт № 6. ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО /МЯНГАН ТӨГРӨГ/

<u>Үзүүлэлт</u>	<u>Эхний үлдэгдэл</u>	<u>Эцсийн үлдэгдэл</u>	<u>Өсөлт/+, бууралт -/</u>	<u>Дүнд эзлэх хувь</u>
<u>Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан</u>	1388500.0	1388500.0		
<u>Дүн</u>	1388500.0	1388500.0		

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 1388500.0 мянган төгрөг, өөрчлөлт ороогүй байна.

3.5.10 Орлогын данс

Үндсэн үйл ажиллагааны орлого 96200.0 мянга, туслах үйл ажиллагааны орлого 13000.0 мянган төгрөг төвлөрүүлжээ.

3.5.11 Зардлын данс

Зардлын данстай холбоотой 16300.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд: Ерөнхий боловсролын сургууль нь тавилга эд хогшил худалдан авах зардлаас 6500.0 мянга, багаж, тоног төхөөрөмжийн зардлаас 6000.0 мянга, бусдаар гүйцэтгүүлэх зардлаас 3800.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1/төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/, 41 дүгээр зүйлийн 41.2.3/ төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах/, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4-т заасныг зөрчиж тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Улсын /орон нутгийн / төсвийн орлого бүрдүүлэлт

Баяндэлгэр сумын ИТХ-ын 2021 оны орон нутгийн төсөв батлах тухай 01 дугаар тогтоолд зааснаар Баяндэлгэр сум тайлант онд 182700.0 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 725100.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Хүснэгт 7. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Хувь хүний орлогын албан татвар	124000.0	136000.0	12000.0	109
Бууны албан татвар	1200.0	1200.0	0	100
Улсын тэмдэгтийн хураамж	2000.0	1700.0	300.0	85
Малд ногдуулах албан татвар	0	235700.0	235700.0	
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	500.0	500.0	0	100
Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж	32000.0	328000.0	296000.0	
Хүү, торгуулийн орлого	18000.0	21000.0	3000.0	116
Газрын төлбөр	5000.0	1000.0	4000.0	20
Нийт дүн	182700.0	725100.0	542400.0	

Малд ногдуулах албан татварыг 2021 оны сүүлийн хасаг жилд авахаар шийдвэр гарсан тул төлөвлөгөө боловсруулаагүй 235700.0 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй, агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн орлого 296000.0 мянган төгрөгөөр давсан нь шонхор шувуу барих зөвшөөрлийн нэг толгойд ногдох хураамж нэмэгдсэнээс шалтгаалан орлогын төлөвлөгөө давахад гол нөлөөсөн байна.

Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3485900.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 3485900.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөжээ.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 97900.0 мянган төгрөгөөр бууруулж 3388000.0 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь 2021 онд ковид-19 цар тахал гарсантай холбогдуулан улс орон даяар өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн нь нөлөөлсөн байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 3553400.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 3250000.0 мянган төгрөгийг урсгал зардалд, 144300.0 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, сум хөгжүүлэх сангаас 77000.0 мянган төгрөгийг зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 2381600.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, 902900.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 120600.0 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, 38900.0 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 109200.0 мянган төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөж гүйцэтгэлээр санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 96200.0 мянган төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 3800.0 мянган төгрөгөөр тасарсан, туслах үйл ажиллагааны орлого 13000.0 мянган

төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 2000.0 мянган төгрөгөөр тасарсан нь covid-19 цар тахлаас шалтгаалжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3471300.0 мянган төгрөг буюу 97.6 хувьтай байгаа нь урсгал болон хөрөнгийн зардлыг хэмнэсэнтэй холбоотой байна.

Урсгал болон хөрөнгийн санхүүжилтээс дутуу зарцуулсан 82100.0 мянган төгрөгийг улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар 1000.0 мянга, Засаг даргын нөөц хөрөнгөөс 81100.0 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 440200.0 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 52600.0 мянга, нийт 575000.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бараа үйлчилгээний зардалд 524900.0 мянга, урсгал шилжүүлэгд 44100.0 мянга нийт 574000.0 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 5000.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж харилцах дансанд 900.0 мянган төгрөг үлдсэн байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих мэдээллээс 419 мэдээллийг хугацаанд нь 19 мэдээллийг хугацаа хоцроож, 876700.0 мянган төгрөгийн 73 мэдээллийг байршуулаагүй байна. Тухайлбал: Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 12 зарлагын гүйлгээний 186700.0 мянга, урсгал санхүүжилтийн 61 гүйлгээний 722700.0 мянган төгрөгийг мэдээлээгүй тул албан шаардлага хүргүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэж байгаа боловч зарим мэдээллийг хангалтгүй мэдээлсэн байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 53000.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт							
Албан шаардлага	1	53000.0	1	17000.0		36000.0	32
Зөвлөмж							
Нийт							

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 3 тусгайн сангийн нийт 9 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 байгууллагад дүгнэлт гаргаж, 5 байгууллага түүврээр хамрагдсан.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 3, “Хязгаарлалттай” 1 /Ерөнхий боловсролын сургууль/ дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нийт 935700.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 21900.0 мянган төгрөгийн 1 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 913800.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 11 зөвлөмжийг хүргүүллээ.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн байна. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд 776600.0 мянган төгрөгөөр санхүүжилтийн орлого илүү, 801600.0 мянган төгрөгөөр үйл ажиллагааны зардлыг илүү нэгтгэсэн;
- Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд 806400.0 мянган төгрөгөөр санхүүжилтийн орлого илүү, 806400.0 мянган төгрөгөөр нийт зарлагыг илүү нэгтгэсэн;
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд 70300.0 мянган төгрөгөөр санхүүжилтийн орлого дутуу, 77200.0 мянган төгрөгөөр нийт зарлагыг дутуу нэгтгэсэн;

4Т.....Т

Дээрх гарсан алдааг аудитын явцад залруулсан.

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

Аудитаар төвлөрүүлэн захирагчид акт, албан шаардлага хүргүүлээгүй.

Төвлөрүүлсэн захирагчид өгсөн 2 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 935700.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 21900.0 мянган төгрөгийн 1 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 913800.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 11 зөвлөмжийг хүргүүллээ.

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Төсөвт байгууллагуудад нийт элэгдлээрээ өртгөө нөхсөн 326 ширхэг үндсэн хөрөнгө байгаа бөгөөд ашиглах боломжгүй хөрөнгийг актлах, ашиглах боломжтой хөрөнгийг дахин үнэлэх боломжийг судлах нь зүйтэй гэж үзлээ.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 АВЛАГА, ӨР ТӨЛБӨРТЭЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

3.1.1 Илрүүлэлт: Төсөвт байгууллагуудад тавих хяналт сулаас авлага, өр төлбөр нэмэгдсэн

3.1.2 Эрсдэл: Дараа оны төсөвт хүндрэл учрах эрсдэл байна

3.1.3 Өгсөн зөвлөмж: Харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж авлага, өр төлбөрийг бууруулах

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

3.2 Сум хөгжүүлэх сантай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт: Сум хөгжүүлэх сангаас зээл хүссэн иргэн, аж ахуйн нэгжийн шалгаруулалт хангалтгүй хийгдсэн байна.

3.2.2 Эрсдэл: Шалгаруулалт хангалтгүй хийгдсэнээр насжилт өндөртэй авлага нэмэгдэж нийт авлагын 54.8 хувь буюу 210500.0 мянган төгрөгийг сум хөгжүүлэх сангийн зээл эзэлж байна.

3.2.3 Өгсөн зөвлөмж: Өмнө олгогдсон зээлийг эргэн төлүүлж, журмын болзол хангасан иргэн аж ахуйн нэгжид сум хөгжүүлэх сангаас зээл олгох

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сүхбаатар аймаг дахь төрийн аудитын газарт 2022 оны 9 дүгээр сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Хавсралт1

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2022.03.25	Аудитын нэр:	Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,	Аудитын код: СБА-2022/03/НА-
Шалгагдсан байгууллагын нэр:	Баяндэлгэр сумын Засаг дарга		Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллаг аас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Нэгтгэсэн үр дүнгийн тайланд орлого, зарлагыг илүү илэрхийлсэн	1578200.0	Залруулсан	Санхүү албаны дарга	А.Дамдинсүрэн
2	Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд орлого, зарлагыг илүү илэрхийлсэн	806400.0	Залруулсан	Санхүү албаны дарга	А.Дамдинсүрэн
3	Нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд	147500.0	Залруулсан	Санхүү албаны дарга	А.Дамдинсүрэн

	орлого, зарлагыг илүү илэрхийлсэн				
	Дүн	2532100.0			